



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 02

№ 01/25 ДУА -2018/11/СТА-ТЦС Мандалговь хот

Г 7
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Сум хөгжүүлэх сангаас үйл ажиллагааны бус сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах зураг төсвийн зардалд **1,500,000** / нэг сая таван зуун мянган/ төгрөгийг зориулалт бусаар санхүүжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д /Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна./, 1.9-д / Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно./ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бус зардалд зарцуулсан **1,500,000** / нэг сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн төрийн сангийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Адаацаг сумын Засаг дарга Ж.Батхөлөг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт хариуцуулав.

ТОГТООСОН!


АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН



АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА  Ж.БАТХӨЛӨГ
НЯГТЛАН БОДОГЧ  Б.ЭНХЖАРГАЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.